



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

Нээлтийн дахин дуудлага худалдаа /Re-Opening Auction Call/-г явуулах тухай

“Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8.1, 8.10.11 дүгээр заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн үнэт цаасны арилжааны Millennium Exchange системд нээлтийн дахин дуудлага худалдаа /Re-Opening auction call/-ны үргэлжлэх хугацааг 5 минут болгон өөрчилж, динамик баримтлах ханш буюу хамгийн сүүлд хийгдсэн хэлцлийн ханшаас 5 хувиар өсч, бууран хэлцэл биелэх тохиолдолд үүсдэг дуудлага арилжааг 2015 оны 1 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн явуулсугай.
2. Энэхүү тушаалыг мөрдөхтэй холбогдуулан системд өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж ажиллахыг Арилжааны алба /Д.Алдармаа/-нд даалгасугай.
3. Дээрх тушаал гарсантай холбогдуулан Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 148 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР